



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлийн 75.7, 75.8, 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг нэгдүгээр хавсралтаар, Татвар төлөгчид татварын боловсрол олгох сургалт, сурталчилгааны 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татвар төлөгчид үйлчлэх газар (Б.Буяннэмэх), хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхийг Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газар (Д.Сайханчулуун)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

151601010



Татварын ерөнхий газрын даргын  
2021 оны 12 дугаар сарын 07 ны өдрийн  
А/119 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## ОЛОН НИЙТИЙН ТАТВАРЫН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

2021-2024 он

### НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН БАРИМТ БИЧИГ

Татварын ерөнхий хуулинд татварын алба бүх нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллахаар заасны дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар төлөгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, татвар төлөх нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхэд бүх нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх цогц бодлого зайлшгүй юм.

Олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр өнөөгийн болон ирээдүйн татвар төлөгчдөд татварын соёл, ёс суртахууныг төлөвшүүлэх, татвар төлөгчийн хууль тогтоомжийн мөрдөлтийг сайжруулж, татварын албаны үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлж, татвар төлөгчдийг эрсдэлээс хамгаалахад оршино.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Татварын алба шинэ үеийн татварын тогтолцооны бодлогын шинэчлэлийг тасралтгүй хийж, энэ хугацаанд олон нийтэд чиглэсэн татварын боловсрол олгох ажлыг тасралтгүй хэрэгжүүлж ирсэн ч уялдаа холбоотой нэгдсэн чиг хандлага бүрдээгүй болохыг хөндлөнгийн байгууллагаас хийсэн “Олон нийтийн татвар төлөх хандлага, татвар төлөгчийн сэтгэл зүй, татварын боловсролын түвшинг тодорхойлох” түүвэр судалгааны үр дүн, 2020 онд Үндэсний статистикийн хорооны хийсэн судалгаагаар далд эдийн засгийн хэмжээ нь манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 9.2-15.7 хувийн хооронд хэлбэлзэж байна гэсэн судалгааны дүгнэлтээс харагдаж байна. Иймд иргэд, олон нийтийн татварын боловсролыг нэмэгдүүлэх өргөн цар хүрээг хамарсан, цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага байгааг тодотгож өгсөн.

Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зарчим

- Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил иргэдийн оролцоог хангах;
- Татварын боловсрол олгох сургалт, сурталчилгаанд мэргэжлийн баг, контент бүтээгчдийн оролцоог чухалчилж, зорилтот бүлэгт хүрэх чанартай бүтээгдэхүүн бүтээх

#### 1.2. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

##### 1.2.1. Хөтөлбөрийн зорилго



Татварын ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах, олон нийтийн татварын боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд иргэн бүрийн үндсэн хуулинд заасан татвар төлөх үүргээ биелүүлж, улс, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулж буй ухамсрыг ойлгуулж, татварын албанд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, татвар төлөгчийг ирээдүйд үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

### 1.2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

1. Олон нийтэд чиглэсэн улсын хэмжээний судалгаа, хэлэлцүүлэг зэрэг томоохон арга хэмжээ зохион байгуулна.
2. Олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, шаардлагатай техник, хүний нөөцийг бүрдүүлнэ.
3. Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.

### 1.2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

Нэгдүгээр үе шат (2021-2022 он): Олон нийтийн татварын боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2023-2024 он): Эхний шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, татвар төлөгчдийн эрэлт хэрэгцээнд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

## ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- 2.1.1. Татварын боловсрол олгох анхан шатны бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг жил бүр хийж, үр дүнг тооцдог болох;
- 2.1.2. “Олон нийтийн татварын боловсрол” олгох хэлэлцүүлгийг 2 жилд 1 удаа зохион байгуулах;

### 2.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 2.2.1. Татварын төлөгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын материал бэлтгэх;
- 2.2.2. Татвар төлөгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн татвар төлөгчийн ангилал, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, татварын төрлөөр сургалт зохион байгуулах;
- 2.2.3. Татвар төлөгчдөд татварын талаарх мэдлэгийг түгээх, тэднийг чадавхижуулах, татварын эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг эзэмшүүлэх шаталсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх;
- 2.2.4. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд татварын тухай ойлголтыг тоглоом, контентоор дамжуулан хүргэх;
- 2.2.5. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт татварын боловсрол олгох агуулгыг оруулах;
- 2.2.6. Их, дээд сургуулийн оюутнуудын сургалтын хөтөлбөрт татварын боловсрол олгох агуулгыг нэмэгдүүлэх, хичээлийн агуулгаас бусад байдлаар мэдлэгийг дээшлүүлэх;



- 2.2.7. Татвар төлөгчдийн боловсролыг цахим хэлбэрээр хүргэх боломжийг нэмэгдүүлэх;
- 2.2.8. Татвар төлөгчид мэдээлэл, сургалт, сурталчилгаа, түүний үр дүнг тооцоход мэдээллийн технологийг ашиглах;
- 2.2.9. Татварын албаны цахим хуудас /www.mta.gov.mn/-ийн мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх;
- 2.2.10. Татварын боловсрол олгох боловсон хүчнийг чадавхижуулах;
- 2.2.11. Татварын боловсрол олгоход шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах;

### **2.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

- 2.3.1. Татвар төлөгчийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаанд /сургалт, сурталчилгаа/ орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх;
- 2.3.2. Их, дээд сургуулиудын оюутнуудыг татварын талаар мэдлэг олгох сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах чиглэлээр дэмжиж ажиллах;
- 2.3.3. Татварын боловсролын сургалт, сурталчилгаа, судалгааны ажилд төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

## **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

### **3.1. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:**

- 3.1.1. Татвар төлөгч хаана, ямар нөхцөлд амьдарч байгаагаас үл хамааран татварын үйлчилгээ, мэдээллийг саадгүй авах нөхцөл бүрдэнэ;
- 3.1.2. Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй болж, татвар төлөх нийгмийн сэтгэл зүй төлөвшинэ;
- 3.1.3. Хууль тогтоомжийн даган мөрдөлт сайжирна;
- 3.1.4. Татварын боловсролыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэдийн оролцоо сайжирна;

### **3.2. Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө:**

- 3.2.1. Татвар төлөгчийн боловсрол дээшилснээр бизнесийн үйл ажиллагаагааг хэвийн явуулах, татварын аливаа эрсдэлээс хамгаалах боломж нэмэгдэнэ;
- 3.2.2. Татвар төлөгчийн татварын хууль зөрчсөний улмаас учрах эдийн засгийн хохирол буурна;
- 3.2.3. Татвар төлөгчид мэдээлэл түгээх цахим сүлжээг нэвтрүүлснээр татварын мэдээллийг хялбар авч, зардал буурна;

### **3.3. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

- 3.3.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ татвар төлөгчдийн дунд хийсэн судалгааг суурь үзүүлэлт болгон ашиглана.

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ**

### **4.1. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:**

- 4.1.1. Татварын албаны төсөв;
- 4.1.2. Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн санхүүжилт;
- 4.1.3. Төрийн болон төрийн бус байгууллагын хөрөнгө;



## **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих чиг үүргийг ТТҮГ, ТХУАЗГ, ТУОУТГ хамтран зохион байгуулж, харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын албад хэрэгжүүлнэ.

5.2. **Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

5.2.1. Татварын боловсролын ангиллаар сургалтын агуулга бэлтгэх, түгээх, нэгдсэн арга зүйгээр хангах;

5.2.2. Сургалтын төлөвлөгөөг жил бүр боловсруулж батлуулах;

5.2.3. Бүх шатны боловсролын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

5.2.4. Татварын боловсролын талаарх үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн, татвар төлөгчийн татварын мэдлэгийн чиг хандлагын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, хамтран ажиллах;

5.2.5. Сургалтын тайланг хагас, бүтэн жилээр гарган, нэгтгэж, дүнг танилцуулах;

5.2.6. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хангаж ажиллах;

5.3. **Харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын албад дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

5.3.1. Татварын боловсролын сургалтын агуулга бэлтгэх;

5.3.2. Бүх шатны боловсролын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

5.3.3. Татварын боловсролыг татвар төлөгчийн ангилал, үйл ажиллагааны чиглэл, татварын төрлөөр зохион байгуулах;

5.3.4. Татварын боловсролыг олгох ажлын тайланг улирал бүр гарган ирүүлэх;

5.3.5. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлж ажиллана;

## **ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд ТЕГ-ын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ газар жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор үнэлгээ хийж, Татварын ерөнхий газрын удирдлагад танилцуулна.

6.2. Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын албад хийсэн ажлын тайланг улирал бүрийн дараагийн сарын 10-ны өдрийн дотор ТЕГ-ын Татвар төлөгчид үйлчлэх газарт ирүүлнэ. Татвар төлөгчдөд үйлчлэх газар улирал бүрийн тайланг дараагийн сарын 20-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор ТЕГ-ын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ газарт хүргүүлнэ.



Татварын ерөнхий газрын даргын  
2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн  
А/110 Дугаар тушаалын 2 дугаар хавсралт

СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ  
2021 ОН

| Д/д                                                                                              | Үйл ажиллагаа                                                                                       | Төсөв                    | Шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                                     | Суурь түвшин                                                                                          | Хүрэх түвшин                                                                                                                                                                                              | Хугацаа       | Хариуцах албан хаагч |
|--------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|----------------------|
| Нэг. Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: |                                                                                                     |                          |                                                                                                                                                                                                                      |                                                                                                       |                                                                                                                                                                                                           |               |                      |
| 1                                                                                                | Олон нийтийн татварын боловсролын зан хандлага, сэтгэл зүйн түвшинг тодорхойлох                     | төсөв                    | Хөндлөнгийн байгууллагаар олон нийтийн татвар төлөх хандлага, татвар төлөгчийн сэтгэл зүй, татварын боловсролын түвшинг тодорхойлуулах судалгаа хийж, дүгнэлт гарган, татварын албаны удирдлагад танилцуулсан байна. | 2020 онд судалгаа хийж, нийт түүврийн 56 хувийг хамруулсан.                                           | 1.Хөндлөнгийн байгууллагаар олон нийтийн татвар төлөх хандлага, татвар төлөгчийн сэтгэл зүй, татварын боловсролын түвшинг тодорхойлуулсан байна.<br>2.Судалгааны дүнг ТЕГ-ын удирдлагад танилцуулж байна. | IV улирал     | ТТҮГ                 |
| 2                                                                                                | Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт Татварын боловсрол олгох асуудлыг тусгуулах                | Үйл ажиллагааны зардлаар | Боловсрол шинжлэх ухааны яаманд Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт Татварын боловсролыг оруулах асуудлаар хүсэлт хүргүүлж, чиглэл авсан байна.                                                                 | Байхгүй                                                                                               | Татварын сэдэвт хичээлийг Ерөнхий боловсролын сургуулийн 2024-2028 оны сургалтын хөтөлбөрт оруулах ажлыг эхлүүлсэн байна.                                                                                 | III-IV улирал | ТТҮГ<br>ТУОУТГ       |
| 3                                                                                                | Төрийн бус байгууллагатай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт зохион байгуулах | төсөв                    | Татварын боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай хамтран ажиллаж, Ерөнхий боловсролын сургуулийн 3 чиглэлээр сургалт хийж, цахимд байршуулсан байна.                                                    | 2020 онд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цахим хичээл бэлтгэж, хүргүүлж байсан. | Татварын боловсрол олгох чиглэлээр ТББ-тай хамтран ЕБС-ийн сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдад цахим сургалт зохион байгуулсан байна.                                                           | II-IV улирал  | ТТҮГ                 |
|                                                                                                  | Татвар төлөгчдийн хэрэгцээ                                                                          | Үйл ажиллагаа            | Хариуцсан чиг үүргийн хүрээнд татвар төлөгчийн зан                                                                                                                                                                   | 2020 онд Том сегмент -39481,                                                                          | Татвар төлөгчийн зан хандлагын дагуу хэрэгцээ                                                                                                                                                             | I-IV улирал   | ТТҮГ,<br>ЗББН        |



|   |                                                                                             |                          |                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                             |                           |
|---|---------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|
| 4 | шаардлагад нийцүүлэн сургалт зохион байгуулж, үр дүнг тооцох                                | аны зардлаар             | хандлагад тохирсон сургалтыг татвар төлөгчийн ангилал, үйл ажиллагаа, татварын төрлөөр зохион байгуулсан байна.                                                                                       | дунд сегмент - 9096, жижиг сегмент – 8248, бичил сегмент – 88409 татвар төлөгч хамрагдсан. 2. ТЕГ-ын ТТҮГ-аас 21 удаагийн сургалт зохион байгуулж, 1862 татвар төлөгчийг хамруулсан. | шаардлагад нийцсэн сургалтыг хийж, өмнөх оноос 5 хувь ахиулсан байна. Сургалтад хамрагдсан татвар төлөгчөөр сургалтын чанарыг үнэлүүлж эхэлсэн байна. Татвар төлөгчийн хууль тогтоомж мөрдөлтийн зан хандлага ахисан байна  |                           |
| 5 | Цахимаар боловсрол олгох үйл ажиллагааг өргөжүүлэх                                          | Үйл ажиллагааны зардлаар | Татварын албаны facebook, youtube, цахим хуудас /www.mta.gov.mn/-ийн мэдээллийн санд цахим хичээл бэлтгэж байршуулсан байна. /татварын төрөл, татвар төлөгчийн ангилал/                               | 2020 оны жилийн эцсийн байдлаар гарын авлага 40, постер 63, онлайн хичээл 15, заавар 5, журам, аргачлал 7, цахим бичлэг 6 хийж, татварын албаны цахим хуудсанд байршуулсан.          | Татварын албаны цахим хуудас /www.mta.gov.mn/-ийн мэдээллийн санг өргөтгөн хөгжүүлж, ААНОАТ, ХХОАТ, НӨАТ, АМНАТ-ын чиглэлээр сургалт хийж, байршуулсан байна.                                                               | IV улирал<br>ТТҮГ, ЗББН   |
| 6 | Малын тоо толгойн албан татварын хуулиар сургалт, сурталчилгааны комик, брошур хийж, түгээх | Үйл ажиллагааны зардлаар | Малчин телевизтэй хамтран малчдад зориулсан теле сургалт 7 удаа гаргах, малчдын татварын боловсролд зориулсан брошур, телевизийн шторк, цахим постер хийсэн байна.                                    | Малчдад зориулсан телевизийн шторк гаргаж, МТА-ны facebook, youtube-ээр байршуулсан.                                                                                                 | Малын тоо толгойн албан татварын хуулиар сургалт, сурталчилгааны комик, брошур хийж, 80 000 малчинд түгээсэн байна. Харьяа нэгжүүд малчдад зориулсан цахим сургалт хийх, брошурын эхийг олшруулж, малчдад хүргүүлсэн байна. | IV улирал<br>ТХУАЗГ, ТТҮГ |
| 7 | Татвар төлөгчийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан тохирсон сургалтын материал боловсруулах; | Үйл ажиллагааны зардлаар | Зорилтот бүлэгт тухайлбал, татвар төлөгчийн ангилал, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, нийтлэг болон тусгайлан хэрэгцээ шаардлагад тохирсон сургалтын материал боловсруулж, цахимд байршуулсан байна. | 2020 оноос татвар төлөгчийн ангилалд зориулсан сургалт хийж эхэлсэн.                                                                                                                 | Татвар төлөгчийн хэрэгцээ шаардлагыг хангасан 5 төрлийн сургалтын материал боловсруулсан байна.                                                                                                                             | I-IV улирал<br>ТТҮГ, ЗББН |



|    |                                                                                           |                          |                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                    |               |           |
|----|-------------------------------------------------------------------------------------------|--------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|-----------|
| 8  | Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд татварын ойлголтыг тоглоом, контентоор дамжуулан хүргэх | төсөв                    | ТАЗИ хөтөлбөрийн хүрээнд зурган эвлүүлэг фазл, буддаг ном, танин мэдэхүйн картыг тус бүр 1000ширхэг хэвлүүлж, бүх нийтийн хүртээл болгосон байна. Ерөнхий боловсролын 3 сургуульд ханын зураг зуруулах, тази аппликейшнд хөгжүүлэлт хийх, ирээдүйн татвар төлөгч хуудсыг тази болгон хүүхдүүдэд мэдээлэл өгдөг болсон байна. | Байхгүй                                                                                                                                                                                                         | Сургуулийн өмнөх насны 1000 хүүхдэд татварын тухай ойлголтыг тоглоом, контент, ханын зургаар дамжуулан хүргэсэн байна. Тази аппликейшнд хөгжүүлэлт хийж, ирээдүйн татвар төлөгч хуудсыг тази болгон хөгжүүлсэн байна.                                              | II улирал     | ТТҮГ      |
| 9  | Татварын албаны веб сайт, олон нийтийн сүлжээнд чатбот ухаалаг үйлчилгээг нэвтрүүлэх      | Үйл ажиллагааны зардлаар | Татварын албаны олон нийтийн сүлжээнд ухаалаг чатбот үйлчилгээг нэвтрүүлсэн байна.                                                                                                                                                                                                                                           | Завлөгөө өгсөн татвар төлөгчийн тоо: 18001288 тусгай дугаарын утас -байцаагчтай холбогдсон 298,672 /ажлын 8 цагаар/ -автомат хариулагчаас 13,281 /24/7 цагаар/ -мэдээлэл эргэж үлдээгээд эргэж холбогдсон 5,988 | 1.Татварын албаны хуудсанд татварын багцалсан автомат үйлчилгээг бий болгох. /чатбот/<br>2.Татвар төлөгчийн түгээмэл асуулт хариултын санг татвар төлөгчийн хэрэгцээ, шаардлага, ангилалд тохируулан веб сайтаар татвар төлөгч ашиглах боломжийг бүрдүүлсэн байна. | II-IV улирал  | ТТҮГ, МТТ |
| 10 | Татварын албаны цахим хуудаст татварын цэс боловсрол шинээр байршуулах                    | Үйл ажиллагааны зардлаар | mta.gov.mn цахим хуудсанд "Татварын боловсрол" цэсийг нээх, татвар төлөгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн гарын авлагыг байршуулсан байна.                                                                                                                                                                                    | Сургалтын нэгдсэн цэс байхгүй                                                                                                                                                                                   | Татварын албаны цахим хуудсанд шинэ цэсийг нэмж, хөгжүүлснээр татвар төлөгчдийн хэрэгцээт сургалтын мэдээллийг /ЕБС, их дээд, сегмент/ цахим хуудсаар шуурхай хүргэх боломжийг бүрдүүлсэн байна.                                                                   | III-IV улирал | ТТҮГ      |
| 11 | Санхүү нягтлан бодох бүртгэлийн их дээд сургуулийн оюутнуудад зориулсан                   | Үйл ажиллагааны зардлаар | Татварын мэргэшсэн зөвлөх, санхүү нягтлан бодох бүртгэлийн их дээд сургуулиудтай хамтарсан арга                                                                                                                                                                                                                              | Татвар төлөгчдийн өдрүүдээр жилд нэг удаа зохион байгуулж байсан.                                                                                                                                               | Татварын мэргэшсэн зөвлөх, санхүү нягтлан бодох бүртгэлийн их дээд сургуулиудтай татварын хууль даган мөрдөлийг                                                                                                                                                    | II-III улирал | ТТҮГ      |



| уралдаан, тэмцээн, сургалт зохион байгуулах                                                                                                          | хэмжээг 2-3 удаа зохион байгуулсан байна. | сурталчлан таниулах уралдаан, тэмцээн зохион байгуулсан байна.                                                                      |                                                                                                                                      |                                                                                                                                                                         |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хоёр. Харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын албад дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ;                                                           |                                           |                                                                                                                                     |                                                                                                                                      |                                                                                                                                                                         |
| 12<br>Бүх шатны боловсролын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах; төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар                  | Орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран татварын боловсрол олгох чиглэлээр улирал бүр сургалт зохион байгуулсан байна. | Зөвхөн төлөгчдийн өдрүүдийн үеэр татвар төлөгчийн сургалт, сурталчилгаанд орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг оролцуулдаг. | Татвар төлөгчийн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр орон нутгийн засаг захиргааны байгууллага, ТББ, боловсролын байгууллагатай хамтран ажилласан байна. |
|                                                                                                                                                      |                                           |                                                                                                                                     | II-IV улирал                                                                                                                         | Харьяа нэгж                                                                                                                                                             |